

ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ДАЯАРШИЛ

*Ц.Баатар**

Эхлэл өмнөх дугаарт

Хятадын эдийн засгийн орчин үеийн асуудлууд

1997-1999 оны Азийн санхүүгийн хямрал нь Ази-Номхон далайн хамтын нийгэмлэгийн /үүний нэг хэсэг нь Хятад улс/ өмнө нилээд хэдэн хурц асуудлыг тавьсан юм. Тухайлбал дэлхийн эдийн засгийн даяаршлын түрэлтэд яаж үр нөлөөтэй дасан зохицох, эдийн засгийн өсөлт хөгжилд түүний боломжийг хэрхэн ашиглах, тэгэхдээ даяаршлын сөрөг үр дагавраас яаж зайлсхийх вэ? Ази, Номхон далайн бүс нутгийн /АНДБН/ орнуудын эдийн засаг, санхүүгийн бодлогыг яаж уялдуулан зохицуулах вэ, санхүүгийн шинэ аюул сүйрлээс хэрхэн хамгаалах вэ, гадаадын хөрөнгө оруулагчдыг хэрхэн татах, хяналт тавих вэ, бүс нутгийн дотоодын хийгээд бүс нутаг хоорондын санхүүгийн урсгалын мониторингод яаж оролцдог болох вэ? Эцэст нь улс орнуудын өсөн нэмэгдэж байгаа эдийн засгийн харилцан хамаарлын зайлшгүй угтвар нөхцөл, үр дагавар болох нээлттэй бодлогыг үндэсний эдийн засгийн эрх ашиг, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах явдалтай хэрхэн хослуулах вэ? гэсэн асуудлууд тавигдсан юм.

Эдийн засгийн даяаршлын түрэлтэд өгөх хариуны нэг ёсны Азийн хувилбар нь АНДБН-ийн орнуудын улам хүчтэй болж буй эдийн засгийн харилцан хамаарал, АНДБН-ийн эдийн засгийн интеграцыг хөгжүүлэх гэсэн тэдгээрийн нийтлэг ашиг сонирхлыг тусган илэрхийлж буй Азийн бүс нутгийн үзэл /регионализм/ болоод байна. Энэ бүсийн интеграцид гурван гол “тоглогч” /АНУ, Япон, Хятад/ асар их үүрэг рольтой нь мэдээж. Сүүлийн жилүүдэд АНУ, Хятад, Япон, Өмнөд Солонгос зэрэг гол тоглогчид Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга уулзалтын хүрээнд бүс нутгийн интеграцчиллыг ямар нэг байдлаар “институтчилах” оролдого хийсээр байна.

Хятад улс АНДБН-ийн эдийн засгийн интеграцид голлон тоглогч байхыг эрмэлзэж байна. Өнөөдөр Азийн бүс нутгийн үзлийн хөгжилд Хятадын эзлэх байр суурийн тухай санаа дэлхийд өргөн тархжээ. Тухайлбал, Хятад ойрын 15-20 жилд Азийн интеграцын төвийн үүрэг гүйцэтгэнэ гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс авахуулаад түүнийг бүс нутгийн эдийн засгийн тогтвортой, зугуухан хөгжилд гол аюул занал учруулах юм шигээр тайлбарлах гэх мэт санаанууд нэн өргөн дэлгэрчээ.

* Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

Хятад улс ДХБ-д элссэнээр дэлхийн хийгээд бүс нутгийн эдийн засагт шинэ шинж төлөв бий болголоо. АНУ, АСЕАН, Япон, БНСУ Хятадыг дайсан гэж үзэхээсээ илүү түншээ гэж үзэх болов. Гэхдээ Хятад нь өөрийнхөө зах зээлийн шинэ шинжид нийцэн зохицохын тулд улс орныхоо нийгэм эдийн засгийн хөгжлийн загварыг засварлах шаардлагатай тулгарч байна. Хятадын орчин үеийн эдийн засгийн онцлог байдал ч үүнд хүчтэй түлхэц өгч байна.

Өнгөрсөн зууны эцэс энэ зууны эхээр Хятад улс захиран тушаах командын эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжихтэй холбоотой эдийн засгийн цоо шинэ асуудлуудтай тулгарсан юм. Дангаар ноёрхох бодлогоос нээлттэй байх бодлогод шилжихтэй бус, харин Хятадыг дэлхийн эдийн засагт татан оруулахтай, Хятадын эдийн засагт дэлхийн эдийн засгийн үйл явцын нөлөөлөлтэй мөн Хятадын эдийн засагт болж буй тэр зүйл Ази-Номхон далайн хийгээд дэлхийн аж ахуйд урвуугаар нөлөөлөхтэй холбогдсон асуудлууд тулгарчээ. Тийм хурц асуудлуудад дефляци, улсын өрийн асуудал, банкны систем, төрийн үйлдвэрийн газруудыг шинэчлэх, валютын зохистой ханшийг сонгох, экспортын өсөлтийн хурдныг хэвээр хадгалах, эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, ажилгүйдлийн өсөлтийг зогсоох зэрэг асуудлууд хамаарч байна.

Дефляци. 1998-1999 онуудад Хятадад дотоодын үнэ 1-2% унасан нь анх удаа ажиглагдсан. Үнийн уналтыг дагалдаад дотоодын эрэлт унаж эхэлж байгаагаас дефляцийн тодорхой аюул ажиглагдсан. Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд ажил хэргийн идэвхжил буурч, үйлдвэрлэл уналтад ордог талтай. Хятадад дефляцийн нэг хүчин зүйл нь 1998-1999 онд экспортын өсөлтийн хурдац бараг тэг болтлоо буурсан явдал байв. /энэ нь Азийн санхүүгийн хямралын дам үр дагавар байлаа. Ц.Б/. Үүний улмаас төлбөрийн чадвартай эрэлт зохих ёсоор нэмэгдээгүй байтал дотоодын зах зээл дээрх барааны нийлүүлэлт нэмэгдсэн. Үйлдвэрлэлийн хэрэгсэл, хэрэглээний барааны үнийн индексийн бууралтын өөр нэг шалтгаан нь эдийн засаг дахь бүтцийн тэнцвэргүй байдал болсон юм. Үр ашиггүй томоохон үйлдвэрийн газруудыг төрөөс дэмжих нь уламжлалт нэр төрлийн барааг хэт үйлдвэрлэж, үнийн тогтворгүй байдал үүсгэн эрэлтээс нийлүүлэлт нь давамгайлахад хүргэдэг байлаа.

Тухайн үед Хятадын эдийн засгийн бодлого боловсруулагчид хөгжингүй орнуудад дефляцийн асуудлыг яаж шийдэж байгааг анхааралтай ажиглаж түүнээс санаа авч нааштай шийдэлд хүрсэн. Тухайлбал, зам гүүр, далан тавих гэх мэт олон нийтийн ажилд болон

орон сууц барих ажилд томоохон хөрөнгө оруулах замаар дотоодын эрэлтийг нэмэгдүүлэх загварыг хэрэглэсэн. Түүнчлэн хэрэглээний эрэлтийг хөхүүлэн дэмжих замаар дотоодын эрэлтийг нэмэгдүүлж байна. Хятадад баярын өдрүүдийн тоог ихээхэн олшруулж, хүмүүсийн ухамсарт хувийн зардлыг нэмэгдүүлэхэд тулгууласан шинэ аж төрөх ёсыг идэвхийлэн нэвтрүүлж, дотоодын аялал жуулчлалыг сайшаан дэмжиж байна. Сүүлийн жилүүдэд дотоодын аялал жуулчлал хүчтэй хөгжлөө. 2000-2001 онд хэдийгээр дефляцийн аюул Хятадын эдийн засагт нүүрлэсээр байсан ч үнийн өсөлтийн индекс тус бүр 0.5%, 0.7% болж байв. /энэ нь 2002 онд ч мэдрэгдэж, үнэ 0.8%-иар унасан байна/.

Улсын өр. Төрөөс томоохон зардал гаргаж, дотоодын эрэлтийн өсөлтийг хөхиүлэн дэмжсэн нь улсын төсвийн алдагдал нэмэгдэхэд хүргэж, албан ёсны мэдээгээр 1996 онд ДНБ-ий 0.8%-ийг эзэлж байсан бол 2002 онд түүний 2.8%-ийг эзлэх болтлоо өсчээ. Хятадад улсын үнэт цаасны борлуулалтаас төрийн банкуудад нийлүүлэгддэг мөнгийг төсвийн орлогод уламжлал ёсоор харуулдгийг харгалзан үзвэл улсын төсвийн бодит алдагдал ДНБ-ий 20-25% болтлоо өсч байна. Гэвч Азийн бусад орны эдийн засагтай харьцуулж үзвэл Хятадын санхүүгийн нөхцөл байдал тийм ч муугүй байгаа. Тус улсын эдийн засагт хөрөнгө оруулалт хийх ихээхэн нөөц баялагийг хувийн хуримтлал бүрдүүлж байгаа ба энэ нь ДНБ-ий 70-80%-д хүрч байна. Харин улсын дотоодын болон гадаад өрийн нийт хэмжээ ердөө ДНБ-ий 35-40%-ийн түвшинд л байна. Хятадын валютын нөөц 200 тэрбум ам. доллараас хол давжээ /2003 онд 286 тэрбум ам.доллар байв/. Энэ байдал нь олон улсын компаниудад Хятадын санхүүгийн ерөнхий нөхцөл байдлыг тийм ч муугүй гэж үзэх боломж олгож байна. Гэсэн ч шинэ зууны эхээр Хятадын үнэт цаасны зах зээл хүнд асуудалтай тулгарч байна. Энэхүү “Пирамид” үүсгэх аюул нь Хятадыг хөрөнгө оруулалтын улсын хийгээд дотоодынхоос өөр эх үүсвэрүүдийг эрж хайхаас өөр аргагүй байдалд оруулж байна.

Хятадын эрх баригчид дээрх хүндрэлийг даван туулахын тулд шинэ зууны эхнээс үндэсний хувийн капиталд ихээхэн найдлага тавьж түүнд гол анхаарлаа төвлөрүүлэх боллоо.

Түүнчлэн фирмүүдийн стратегийн төлөвлөлтөд төрөөс анхаарал тавьж эхэллээ. Урьд өмнө Хятадын фирмүүдийн үйл ажиллагааны стратеги нь өрсөлдөөн дэх давуу тал болон зах зээлийн эрэлт шаардлагад тулгуурласан бус, харин бусдын стратегийг хуулбарласан байдалтай байлаа. Гэтэл одоо тэд дэлхийн улс төрийн бодлого, орчны өөрчлөлт, дэлхийн эдийн засгийн даяаршил, мэдлэгт тулгуурласан эдийн

засаг, өндөр технологийн хөгжил зэрэгтэй уялдуулан үйл ажиллагааныхаа стратегийг өөрсдийн урт хугацааны. тогтвортой хөгжлийн нэг гол баталгаа хэмээн ойлгож, түүнийг боловсруулахдаа олон талын судалгаан дээр үндэслэн төлөвлөх болсон байна.

Даяаршлын үйл явцтай дотоод эдийн засгийн механизмаа уялдуулан зохицуулах, фирмүүдийн менежмент, төлөвлөлтийг хөгжингүй орнуудын фирмүүдийн түвшинд хүргэх үүднээс эрх баригчид энэ мэт олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Улсын үйлдвэрийн газруудын шинэтгэл ба ажилгүйдлийн өсөлт

Хятадад улсын үйлдвэрийн газруудыг төрийн өмчид бүрэн тулгуурласан, төрийн хяналтын багцтай янз бүрийн компани, хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд болгон өөрчлөн байгуулах ажил үе шаттай явагдсан. Ингэснээр хөрөнгө оруулагчдын эрх ашиг, үйлдвэрийн газруудын үүрэг амлалтыг илүү тодорхой болгожээ. Өмч хөрөнгийн биеэ даасан эрх бүхий хууль ёсны этгээд болсноор үйлдвэрийн газруудын статусыг боловсронгуй болгох боломж олгожээ. Ингэснээр аж ахуйн үйл ажиллагааны үр дүнгийн төлөө “пүүсийн дотоод” удирдлагын төлөө төр бус, чухамдаа үйлдвэрийн газрууд хариуцлага хүлээдэг боллоо. Хятадад “орчин үеийн үйлдвэрийн газруудын системийг” бий болгох үндсэн арга хандлага нь ийм байна. Одоогийн шинэтгэл нь улсын үйлдвэрийн газруудын бүтцийг өөрчлөх үзэл баримтлалын тав дахь цуврал үе шат юм. Үүний өмнө: 1979-1980 онд үйлдвэрийн газруудын аж ахуйн бие даасан байдлыг өргөжүүлсэн. 1981-1983 онд аж ахуйн хариуцлагын систем нэвтрүүлсэн. 1984-1986 онд улсад тушаах ашгийн шимтгэлийг татвараар сольж, 1987 оноос төрд ашгийг шилжүүлэх гэрээг нэвтрүүлсэн. 1990-ээд оны сүүлчээс хувь нийлүүлэх, корпорациудыг байгуулах замаар мянга мянган томоохон үйлдвэрийн газрыг шинэчлэхэд онцгой анхаарч эхэлсэн. Гэвч энэхүү шинэтгэл нь аливаа бүтцийн өөрчлөлтийн нэг адил нийгмийн хохиролгүйгээр явагддаггүй нь тодорхой. Тухайлбал, Хятадад ажилгүйдлийн давалгаа хүчтэй ажиглагдах болов. Тусгай судалгааны мэдээгээр одоо хотуудын албан ёсоор бүртгэгдсэн ажилгүйдчүүдийн тоо 5 саяас давж байна. Түүнээс гадна хотын яг ажилгүй байгаа хүний тоо 30 сая орчим болж байна. Үүн дээр жилд 3 сар хүрэхгүй хугацаагаар ажилтай байдаг хөдөөгийн 180 сая хүн нэмэгдэнэ. Энэ тоонуудыг нийлүүлбэл 215 сая болох бөгөөд энэ нь хөдөлмөрийн чадвартай хүмүүсийн гуравны нэг орчим гэсэн үг.

Нөгөөтэйгүүр ажилгүйчүүдийн тоо өсч буй нь Хятадаас Зүүн Өмнөд Азийн хөрш орнууд, АНУ, Япон, Орос руу нууцаар цагаачлагчдын тоо нэмэгдэхэд хүргэж байна. Хятадын хүн амын тоог, тэр байтугай процентын харьцаагаар ялихгүй ч гэсэн, харгалзан үзвэл хөрш орнууд руу нууцаар цагаачлагчдын урсгал нэмэгдэж байгаа нь тэдгээр орны нийгмийн нөхцөл байдлыг хүндрүүлээд зогсохгүй, Хятадын нууцаар цагаачлагчдын асуудал нь цаашдаа бүс нутгийн хэмжээний асуудал болон хувирч ч болзошгүй.

Экспортыг нэмэгдүүлэх зорилт ба валютын ханшны асуудал

1997 оны сүүлчээс 1999 оны дунд үе хүртэл Хятадын экспортын өсөлт түр зогсож, барааны өрсөлдөх чадвар харьцангуй уналтад орсон нь Азийн санхүүгийн хямралын дам уршиг дагавар байв. Энэ хямрал Азийн нилээд хэдэн орны валютыг унагасан ба ингэснээрээ нэгдүгээрт, эдгээр орны экспортлогчдыг дэлхийн болон бүс нутгийн зах зээлд Хятадын өрсөлдөгчдийг бодоход илүү ашигтай байдалтай болгосон юм. Хоёдугаарт, Хятадын бүтээгдэхүүнийг худалдаж авах Азийн улсуудын импортын эрэлтийг багасгасан. 2000 онд Хятадын экспорт 28%-иар өссөн боловч 2001 онд түүний өсөлтийн хурдац нь АНУ, Европын Холбооны эдийн засгийн өсөлт удааширч, Японы эдийн засаг уналтад орсонтой холбогдоод ердөө 6% болжээ. 2001 онд Хятадын худалдааны ашиг нь 22.5 тэрбум доллар байхад гадаад худалдааны хэмжээ 510 тэрбум доллар болж байв. 2002 онд ДХБ-ын хүчин зүйлийн нөлөөгөөр экспорт 22%-иар өсч, харин гадаад худалдааны хэмжээ 600 тэрбум доллараас давжээ. Хятадын эдийн засгийн үндэсний эрх ашгийн үүднээс үзвэл тус улсын юанийн ханшийг бууруулах явдал Хятадын зүй ёсны хариу алхам болох ёстой байсан ба ийм замаар Хятадын экспортын Азид хийгээд дэлхийд эзлэх байр суурийг сэргээж болох байв. Гэвч бүс нутгийн хөршүүд нь Хятадад улс төрийн хүчтэй шахалт үзүүлж, юанийнхаа ханшийг бууруулахгүй байхыг шаардсанаас гадна хэрэв юанийн ханшийг бууруулвал бүс нутгийн санхүүгийн донсолгооны шинэ давалгаа үүсгэж, улс орныхоо эдийн засагт шинэ сөрөг уршиг удаж мэднэ гэж болгоомжилсон учир Бээжин Азийн валютын ханш аргагүйн эрхээр буурсан ч гэсэн түүний хариу болгож, үндэснийхээ валютын ханшийг бууруулах талаар тодорхой алхам хийлгүй тэвчиж өдий хүрсэн.

Хятад улс үндэсний валютын ханшаа сүүлийн 9 жилийн турш тогтмол барьж ирснийг бид сайн мэднэ. Гэтэл 2005 оноос Хятадын

үндэсний валютын ханшны болзошгүй өөрчлөлтийн талаар олон улсын санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчид таамаглал дэвшүүлж эхэлсэн. Энэ нь юаний ханшны өөрчлөлт дэлхийн томоохон хөрөнгө оруулагчид төдийгүй хөгжингүй болоод хөгжиж буй орны эдийн засагт асар их нөлөөтэй учраас тэдний анхаарлыг зүй ёсоор татаж буй хэрэг юм. 2005 оны аравдугаар сард болсон хөгжингүй орнуудын G7-ын уулзалтаар Хятад улс юаний ханшаа аль болох түргэн хугацаанд чангаруулах шаардлагатайг авч хэлэлцсэнээс үзэхэд энэхүү асуудал нь дэлхий нийтийг хамарсан чухал асуудал болоод байгааг харуулж байна.

Өнөөдөр Хятад улсын эдийн засаг хурдтайгаар өсөж байгаа бөгөөд ялангуяа гадаадын санхүүгийн хөрөнгө оруулалт хүчтэй нэмэгдэн, тэр хэмжээгээр валютын нийлүүлэлт дотоод зах зээлд нь байнга өсөн нэмэгдэж байна. Ийм нөхцөлд Хятад улс ханшаа удаан хугацаанд тогтмол барих нь түүнд улам бүр дарамт учруулах нь мэдээж.

Олон улсын зарим шинжээчдийн тооцоолж байгаагаар юаний ам.доллартай харьцах зах зээлийн бодит ханш нь одоогийн мөрдөж буй ханшаас даруй 40 хувиар чанга байгаа аж. Эдийн засагчдийн хэрэглэдэг Big Mac Индексээр бол АНУ-д бургерийн үнэ дундач 3 ам.доллартай харьцуулахад Хятадад бургер хамгийн хямд буюу 1.26 ам.доллар байдаг аж. Энэ нь юаний Big Mac-ийг худалдаж авах доллараар илэрхийлсэн ханш 58 хувиар доогуур тогтоогдсон байна гэсэн үг юм. Хятадын худалдааны гол түнш болох Америкийн Нэгдсэн Улс юаний ам.доллартай харьцах ханш ийнхүү зах зээлийн журмаар байх ёстой хэмжээнээсээ хамаагүй сул, түүнийг ийнхүү хиймлээр бага түвшинд барьж байгаа нь шударга бус хэрэг хэмээн буруушааж байна. Учир нь Хятадын экспорт Америкийн хэрэглэгчдэд хямдхан тусаж, харин Америкийн Хятад уруу гаргах экспорт илүү үнэтэй байгаагаас түүний хэмжээ нь буурч АНУ-ын гадаад худалдааны алдагдал улам бүр нэмэгдэх болсон байна. 2004 оны 12 дугаар сард 9.9 тэрбум ам.доллар байсан энэхүү алдагдал нь 2005 оны 1 дүгээр сар гэхэд 11.5 тэрбум доллар болж өсчээ.

Олон улсын санхүүгийн байгууллагууд Хятад улс үндэсний валютын ханшаа 2005 оны эцэс эсвэл 2006 оны эхээр өөрчилнө гэсэн хүлээлттэй байсан.

Саяхан болтол Хятадын судлаачид болон Ардын банкны мэргэжилтнүүд юаний ханшийг заавал өөрчлөх шаардлага байхгүй гэсэн эсрэг байр суурь баримталж байсан боловч өнөөдөр байдал ийнхүү өөрчлөгдлөө. Санхүүгийн Меррилл Линч компаний 2005 оны

дөрөвдүгээр сард хийсэн прогнозоор бол Хятад улс юаний ханшаа дор хаяж 10 хувиар чангаруулна гэсэн таамаглал дэвшүүлж байв. Өөрөөр хэлбэл 10 хувиар өөрчилсөн тохиолдолд 8.28 орчим юаньтай тэнцэж байсан нэг ам.доллар 7.4 орчим юаньтай тэнцэхээр болно гэсэн үг.

Дээрх таамаглал оргүй биш болох нь 2005 оны сүүлтээр Хятадын төв банкнаас гаргасан нийтлэлд тусгалаа олжээ. Нийтлэлд өгүүлснээр бол Хятадын төв банк үндэсний валютынхаа худалдааг монополчлохоос татгалзах гэнэ. Хятадын Валютын хяналтын газраас мэдээлснээр бол 2006 онд юаний ханшийг Төв банкнаас хянадаг хатуу хяналтыг сулруулах үүднээс валютын зах зээлийн хүрээлэн байгуулах аж. Ардын банк 6 тэрбум ам.долларыг 1:7.85 ханшаар худалдан авах бэлтгэлийг хангажээ. Энэ бол дотоодын зах зээлд юаний ханшийг одоогийнхоос 2,9 хувиар өсгөх бодлого гэж шинжээчид үзэж байна.

Хятад улс эдийн засгийн хэт өсөлтөөс эмээдэг ч энэ үзүүлэлт хурдацтай хэвээр байгаа ба зарим салбарт их бага хэмжээгээр удаашралт бий. Экспорт өргөжихийн зэрэгцээ өрхийн орлого, хөрөнгө оруулалт тогтвортой төвшинд байгаа нь эдийн засгийн идэвхийг өрнүүлж байна. Түүнчлэн, Хятад Улс нь ДХБ-тай идэвхтэй хамтран ажиллаж байгаа нь улс орныг улам нээлттэй болгох, эдийн засгийн өсөлтийг хангахад ихээхэн үүрэгтэй гадаадын хөрөнгө оруулагчдыг татахад чухал хүчин зүйл болж байна. Ийм үсрэлтийн үе шат байгаа хэдий ч тогтвортой оршсоор байгаа тэнцвэргүй хөгжлийн байдлыг арилгаж чадахгүй байна. Эх газрын бүс нутаг, эрэг хавийн мужаас хөгжлөөрөө эрс ялгаатай ба маш их хэмжээний хөдөөгийн хүн ам эдийн засгийн хөгжлийн гадна хэвээр байсаар байна. Улсын үйлдвэр, банкны салбарын шинэчлэл удаан явагдаж, муу зээлтэй байгаа алдагдалтай улсын компанийг тэтгэсэн хэвээр байна. Ийм компаний тухай санхүүгийн мэдээллийг авахад төвөггүй хэдий ч төлбөрийг гүйцэтгэхгүй байгаа тохиолдолд нэхэмжлэлийг шаардах нөхцөл хангагдаагүй, эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй. Ойрын хугацаанд үйлдвэрийн газар шаардлагатай хэрэгцээг улсын санхүүгийн байгууллага хангаж чадахгүй ч өсөн нэмэгдэж байгаа улсын үйлдвэрийн өр төлбөр нь нийгэм эдийн засгийн шинэчлэлд муугаар нөлөөлсөөр байна. Гэвч санхүүгийн гадаад нөхцөл нааштай, валютын нөөц өсч байгаа гэсэн нааштай үнэлгээг Олон улсын үнэлгээний байгууллага өгчээ.

Хүн амын нийгмийн давхраажилт

Сүүлийн үед Хятадад тус улсын шинэтгэлийн сөрөг талуудад анхаарлаа хандуулсан олон бүтээл нийтлэгдэж байна. Хятадын судлаачид

хүн амын нийгмийн давхраажилтыг, нийгмийн анги нийгмийн бүтцэд хөрөнгө чинээ багатай хүмүүс зонхилсон үед эд баялагийг цөөн хүний мэдэлд төвлөрүүлэх явдлыг нэн хурц асуудалд хамруулж буй нь үндэслэлгүй хэрэг биш. Хятадын ядуу болон хангамж багатай гэр бүлүүдийн 40%-д тус орны бүх мөнгөн хөрөнгийн 12 хүрэхгүй хувь нь ногдож байхад илүү баян чинээлэг, гэр бүлүүдийн 7% нь бүх мөнгөний 30%-ийг эзэмшдэг байна.

Энэ асуудал нь Хятадын хувьд уламжлал болсон, хувийн хийгээд улсын өмчтэй харилцахтай холбоо бүхий ёс суртахууны талтай юм. Хятадын нийгмийг судлаачдын тэмдэглэсэнээр 1950-1970-аад онд тус улсад социалист ёс зүй ноёрхож байх үед өгөөмөр сэтгэлийг сурталчилж, “хувийнхаас” “нийтийнхийг” илүү эрхэмлэх ёстойг номлож байв. Онолдоо болохоор “хувийн өмчийн халдашгүй байдлын” үзэл санааг шүүмжилж, хувийн өмчийг эрх зүйн талаар хамгаалдаггүй байв. Хүмүүсийн ухамсарт хувийн болон нийгмийн өмчийн хооронд зарчмын ялгаа байгаагүй. Учир нь хүн бүр өөрийгөө нийгмийн өмчийг эзэмшигч гэж үздэг байв. Цаашилбал: “хувийн өмчийг хамаг гай зовлонгийн эх үндэс” мэтээр төсөөлж, хувийн өмчийн халдашгүй ариун байдлыг шүүмжлэх явдал нь “бусдын халаас руу гараа шургуулах” гэсэн эдийн засгийн ёс зүйг нууц хэлбэрээр төлөвшүүлж ирсэн хэлбэр юм. Хувийн болон нийгмийн өмчийг буруу ташаа ойлгох явдал нь зах зээлийн өөрчлөн байгуулалтын үйл явцад нийгмийн өмч хувь хүмүүсийн мэдэлд аяндаа шилжиж, улсын эд хөрөнгө илэрхий үрэн таран болж, нийгмийн хөрөнгийг хувийн зорилгоор ашиглахад нэрмээс болж ирсэн ба энэ бүхнийг бүрнээ байж болох зүйл гэж үздэг болов. Түүнчлэн эдийн засгийн нийт үр ашгийг дээшлүүлэх зорилалтад бодитойгоор нийцүүлэн орон сууцны хуваарилалт, боловсрол, эрүүл мэндийн системийг арилжааны хэлбэртэй болгох замаар нийгмийн асуудлыг шийдвэрлэх оролдлого нь зөвхөн мөнгө олж чадсан юмуу мөнгө “халаасалж” хөрөнгө “хумсалж” чадсан хүмүүс, бодитой буюу субъектив шалтгаанаар ингэж чадаагүй хүмүүсийн хоорондын зааг ялгааг улам нэмэгдүүлж буйг судлаачид тэмдэглэж байна.

Эрчим хүчний аюулгүй байдал

Хятадын шинжээчид 2000-2010 онд тус улсын эдийн засгийн эрчим хүчний нөөцийн хэрэгцээний түргэн өсөлтийг /жилд 3.3%-ийн хэмжээгээр/ таамаглахдаа, Хятадын эрчим хүчний эх үүсвэрийн талаархи эрэлтийг хангахад нефть, хий, нүүрсний үндэсний нөөц илт хүрэлцэхгүй байгааг заан тэмдэглэж байна. Тэгэхдээ тэд Хятадын эрчим хүчний аюулгүй байдлыг Ази, Номхон далайн эрчим хүчний аюулгүй

байдалтай бүхэлд нь холбон үзэж байна. “Хятадыг оролцуулалгүйгээр, түүнтэй хамтран ажиллахгүйгээр АНДБН-ийн эрчим хүчний аюулгүй байдлыг хангах арга байхгүй” гэж тус улсын энэ салбарын эрдэмтэд үзэж байна. Эрдэмтэд 2010 он гэхэд дэлхийн эрчим хүчний хэрэгцээ АНДБН-ийн орнуудаас АНУ, ОХУ-ыг оролцуулахгүйгээр 28% болтлоо өсөх төлөвтэй байгааг түгшүүрийн дохио болгон иш татаж байна. Гэтэл мөн он гэхэд дэлхийн шагдаг хийн нөөцөд тэдгээрийн эзлэх хувь дөнгөж 7%, нефтийнх 4% болох аж. Хятад улс Азийн эрчим хүчний аюулгүй байдлын салбарт бүс нутгийн хоршилтыг зохион байгуулах замаар энэхүү болзошгүй хямралаас гарч болно гэж үзэж байна.

Банкны системийн шимтгэл

Хятадын санхүүгийн системийн хүчтэй ба сул талууд нь одоогоор зөвхөн өрнөдийн маягийн зах зээлийг баримжаалан хөгжиж буйтай бүх талаар холбогдоно. Дээр тэмдэглэсэнчлэнгээр 90-ээд оны дунд үеэс эхлэн Хятадын эдийн засаг захиран-хуваариалах механизмыг бус зах зээлийн механизмыг ашиглах тал хүчтэй болж ирсэн ч санхүү банкны системд энэ чиг хандлага төдийлөн нэвтрээгүй өдий хүрч ирсэн. Хятадын санхүү банкны систем нь төвлөрсөн журмаар хуваарилагддаг материаллаг нөөц баялагийг тооцоолох бус, харин зээл мөнгөний урсгалд үйлчлэх ажил эрхэлдэг гэсэн дүгнэлтийг эндээс хийвэл зохино. Нөгөөтэйгүүр Хятад дахь зах зээлийн эдийн засгийн дотоод учир зүйн үйлчлэлийн хүрээ төрийн хөндлөнгийн оролцоогоор /жишээ нь алдагдалтай үйлдвэрийн газрууд дампуурахгүй байх нь цөөнгүй бөгөөд харин төрийн зүгээс санхүүгийн тэтгэлэг авдаг/ хязгаарлагдсан хэвээрээ ба тус орны санхүүгийн бүх байгууллагын үйл ажиллагааны зах зээлийн дотоод учир зүйн хязгаарлалтыг ч араасаа дагуулсаар байна. Хэрвээ Хятадын санхүү банкны секторыг хөгжингүй зах зээлийн эдийн засгийн байр сууринаас авч үзвэл түүнийг дараах сул бүрдэл хэсгүүдийг онцлон авч үзэж болох юм.

Нэгдүгээрт, энэ нь их хэмжээний эргэн төлөгдөх боломжгүй /”юмуу”, өөрөөр хэлбэл хугацаа хэтэрсэн, найдваргүй/ зээлүүд. Өөр өөр үнэлгээгээр энэ нь Хятадын ДНБ-ний 40-45% хүртэл хэмжээтэй болж буй аж. Уг үзүүлэлт Япон, БНСУ, Тайвань зэрэг Зүүн Азийн бусад орныг бодоход илүү өндөр байна. “чанаргүй муу зээлийн” гол шалтгаан нь зах зээлийн харилцааны системд төлөвлөлтийн элементүүд хэвээр хадгалагдаж байгаад оршино. 1998 оноос эхлэн удирдамжийн дагуу төлөвлөгдсөн “зээлийн хэмжээ хязгаар”-ыг өөрчилж, арилжааны

банкнуд өөрсдийнхөө зээлийн бодлогод илүү чөлөөтэй болсон ч төрийн банкуудын хувьд чиглүүлэгч гэгддэг хэвээр үлджээ. Төрийн банкууд засгийн газрын даалгавраар улсын үйлдвэрийн газруудыг тэдгээрийн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнгээс үл шалтгаалан санхүүжүүлэх үүрэг хүлээдэг. “чанаргүй муу ерийн” нийт хэмжээнд улсын үйлдвэрийн газруудын эзлэх хувь хэмжээ удаан хугацааны зээлээр 70% орчим, богино хугацааны зээлээр 55% болж буй аж.

Хоёрдугаарт, зээлийн нөөцийг үр ашиггүй ашиглах явдал хэвээр байна. ДНБ-тэй харьцах М2 үзүүлэлтийн харьцаа нь одоо 170%-д хүрээд байна. Энэ нь дэлхийд хамгийн өндөрт тооцогдох нэг үзүүлэлт юм. Тэгэхдээ банкууд дахь хүн амын халгаламжийн хэмжээ ДНБ-ий 80% орчим болж байна. Халгаламжийг хөрөнгө оруулалт болгон хувиргах явдал Хятадын банкны системийн нэг гол чухал зорилт болж байна. Үүнийг шийдвэрлэхэд хөрөнгийн зах зээлд халгаламжийн 90%, хөрөнгө оруулалтын 70 гаруй хувь нь ногдож байдаг төрийн 4 том банкны монопол саад болж байна. Төрийн банкууд гол төлөв улсын үйлдвэрийн газруудыг /1990-ээд онуудад төрийн банкуудаас олгогдсон бүх зээлийн 85-90% нийлүүлэгддэг байсан/ санхүүжүүлдэг ба статусыг нь үндсэн хуулиар бататгасан хэдий ч хувийн бизнест болгоомжлонгуй хандсан хэвээр байна.

Гуравдугаарт, “хөрөнгийн хангалттай байдлын норматив /нийт активд өөрийн капиталын эзлэх хувь/” гэх мэт банкны найдвартай байдлын үзүүлэлтийн хэмжээ доогуур байна. Өөр өөр үнэлгээнүүдээс үзвэл Хятад улс зөвхөн 1999 онд OECD-ийн зөвлөмжилсөн 6%-ийн түвшинд хамгийн том 4 банкаар тогтоосон үнэ үзүүлэлтийг хүргэхийн тулд 30 тэрбумаас /албан ёсны тооцоогоор/ 60 тэрбум долларын сангийн тусгай хөрөнгө гаргажээ. Үүнийгээ 10% хүртэл өөрөөр хэлбэл хөгжиж байгаа улсуудад зохистой гэж үздэг тэр хэмжээнд хүргэхийн тулд тус улсад 100 тэрбум орчим доллар /Хятадын ДНБ-ий 10% орчим/ шаардагдана.

Дөрөвдүгээрт, ажиллах хүчинд их зардал зориулж байгаа ба Хятадын банкуудын хөдөлмөрийн бүтээмж бага байна. Хятадын банкны сектор дахь 150 мянган банкинд болон тээврийн салбаруудад 1.7 сая ажилтан ажиллаж байна. “Ажиллагсдын тоонд активын харьцах харьцааны” үзүүлэлтээр тус улс дэлхийн бүх орноос хоцорч байгаа Хятадын хамгийн том 4 банкны албан хаагчдын хөдөлмөрийн хөлсөнд орлогынхоо 85-90%-ийн зарцуулдаг. Хятад улс ДХБ-д элссэнээр санхүүгийн системээ зайлшгүй шинэчлэх шаардлагын тухай асуудал нэн хурцаар тавигдсаар байна. Хятадын банкуудын өнөөгийн сул дорой нөхцөл байдал гадаад ертөнцөд санхүүгийн системээ нээж өгөх нь Азийн хямралыг давтах,

тэгэхдээ Хятадын нутагт давтагдах аюултай гэдгийг Хятадын удирдлага тов тодорхой мэдэж байгаа. Нөгөө талаар санхүүгийн системээ илүү ихээр нээж өгөлгүйгээр, санхүүгээ либералчлалгүйгээр гадаадын шинэ хөрөнгө оруулалтыг бөөнөөр нь оруулж ирнэ гэж найдахад хэцүү. Ингэхлээр нээлттэй байхын тулд бэхжих хэрэгтэй. Өөрөөр хэлбэл санхүүгийн системээ хөгжлийн садаа болж буй түүний гол асуудлаас ангижруулах хэрэгтэй гэсэн нэн оновчтой дүгнэлт гарч байна.

Хятадын эдийн засгийг хувьчлах юмуу либералчлах замаар хурдан шинэчлэх боломжтой эсэх тухай асуултад хариулахын тулд дараах шийдвэрлэх 3 нөхцөл шалтгааныг тухайлбал: Хятадад томоохон хувийн капитал байхгүй байгаа, хувь хүмүүсийн банкинд мөнгөө хадгалуулах сонирхол бага байгаа, улстөр-үзэл суртлын хүчин зүйл нөлөөлж буй зэрэг шалтгааныг зайлшгүй харгалзан үзвэл зохино. Томоохон хувийн капитал байхгүй байгаагаас болоод илүү оновчтой байдлаар буюу төрийн өмчийг шинэ эздэд худалдаалах замаар хувьчлах боломж олдохгүй байна. Үйлдвэрийн газруудын удирдлагыг чухамдаа засаг захиргааны замаар тэдгээрийн эзэд болгон хувиргах гэсэн хувьчлалын хувилбар үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж чадахгүй гэдгийг шилжилтийн эдийн засагтай орнуудын туршлага харуулсан. Улсын үйлдвэрийн газруудын хувьцааг үнэт цаасны зах зээлд аль болох их хэмжээгээр гаргах замаар төрийн өмчийг капиталчилж байж энэ байдлаас гарч болох юм. Гэхдээ Хятад улс зөвхөн хувь хүмүүс хадгаламжаа банкны хадгаламжаас хувьцаанд шилжүүлэн байршуулах сонирхол төрүүлэхүйц оновчтой арга хэрэгсэл, учир шалтгааныг олох төдийгүй хувьчлах зорилгыг хэрэгжүүлэх хэрэгсэл болох Хятадын үнэт цаасны зах зээлд гадаадын худалдан авагчид хүрэх бололцоог хөнгөвчлөх шаардлага ч тулгарч байна. Эхний зорилтыг шийдвэрлэхийн тулд тус оронд хувьцааны зах зээлийг цаашид хөгжүүлэх талаар багагүй хүчин чармайлт, цаг хугацаа шаардагдах нь мэдээж. Төрийн мэдлийн хувьцааны хоёрдогч зах зээлд хүрэх боломжийг олгох хэрэгтэй. /Үүнийг одоохондоо хийгээгүй байна/. Хоёр дахь зорилтыг шийдвэрлэхийн тулд санхүүгийн нээлттэй байдлаа аль болох их болгох хэрэгтэй. Энэ нь өрсөлдөөнийг нэмэгдүүлэх ба ингэснээр үндэсний санхүүгийн үйл ажиллагааг шинэчлэх эхлэл болно.

“Мөнгөний хөшгийг” зайлуулах явдал нь онолын хувьд тодорхой. Юу гэвэл түүний нэг хэсэг нь хэрэглээний эрэлтийг бий болгоход зориулагдаж, нөгөө хэсэг нь бараа, үйлчилгээний эрэлт нийлүүлэлтийг хангадаг хөрөнгө оруулалт болохоор үүнийг хийх хэрэгтэй. Гэвч онолын

тийм жорыг хэрэгжүүлэх механизмыг практикт хараахан нэвтрүүлээгүй байна. Үндэсний банкны системд итгэх Хятадуудын итгэл нь одоохондоо төрийн банкин дээр тогтож байна. Энэ утгаар авч үзвэл чухамдаа төрийн банкууд хэдийгээр системийн чөлөөт зах зээлийн хөгжилд саад учруулж байгаа ч түүний тогтвортой байдлыг хангаж байна. Зах зээлийн дотоод учир зүйг тууштай хэрэгжүүлж төрийн банкуудад их өртэй улсын үр ашиггүй үйлдвэрийн газруудыг дампууруулахын зэрэгцээгээр төрийн банкуудыг хувьчилбал аюултай нөхцөл байдалд хүргэж мэднэ. Хувьчлагдсан банкууд ард иргэдийн асар их мөнгийг цуглуулан хураахын сацуу өрөө төлөх найдваргүй атлаа улсын үйлдвэрийн газруудад зээлдүүлэгч хэвээр байгаад байвал итгэл алдах ноцтой хямралтай тулгарч ч болзошгүй. Тэгэхдээ төрийн банкуудад итгэх ард иргэдийн итгэл хувьчлагдсан банкны бүтцүүдэд шилжих нь юу л бол. Сүүлчийн энэ нөхцөл шалтгаан нь банкуудаас мөнгө зугааалгаж, хувьчлагдсан банкууд мөнгөө хадгалуулсан хувь хүмүүст өрөө төлж чадахгүй байдалд хүргэж мэднэ. Ийм учраас Хятад улс банкны болон аж үйлдвэрийн хүрээнд эрс опцом хувьчлал явуулж эхлэхээс өмнө, нэгдүгээрт, төрийн гол банкуудыг “муу” зээлээс “цэвэрлэх” хэрэгтэй. Үүнийг хийж эхэлж байгааг бид дурдсан. Хоёрдугаарт, хувийн эрэлт, хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих талаар арга хэмжээ авах шаардлагатай. Гуравдугаарт, хүмүүсийн хадгаламжийг хөрөнгө оруулалт болгон хувиргах талаар явуулах ажлынхаа явцад үндэсний банкуудтай адил тэгш эрх олгох учиртай өрнөдийн банкуудыг үндэсний банкуудтайгаа адил байх нөхцлийг бүрдүүлж өгөх зэрэг асуудлууд хариу хүлээж байна.

Эдийн засгийн даяаршилд нэгдэх Хятадын бодлого

Хятад улс эдийн засгийн хөгжлийн гадаад хүчин зүйлүүдийн үүрэг ролийг нэмэгдүүлэхийн тулд эдийн засгийн даяаршлын шаардлагыг тоомсорлохгүй байж болохгүй гэж үзэж түүнд аль болох дасан зохицохыг эрмэлзэж ирэв. Тийм ч учраас Хятадын удирдлага эдийн засгийн даяаршил болон регионализмд эергээр хандаж байна. Хятад шинэтгэлийн чиг бодлогоос үүдэн гарсан дотоодын эдийн засгийн хийгээд санхүүгийн зорилтуудыг шийдвэрлэхийн тулд эдийн засгийн даяаршил, нээлттэй бүс нутагчлан хөгжүүлэх үзэл баримтлалыг ашиглахыг эрмэлзэж байна. Юуны өмнө хөгжингүй орнуудын барааны зах зээлд гарах, тэдгээрийн хөрөнгө, орчин үеийн технологид хүрэх боломж олохыг эрмэлзэж байна. Энэ нь ДХБ-д элссэнээр хангагдана гэж үзсэн. Хангагдаж ч байгаа билээ. Хятадыг эдийн засгийн даяаршил болон Азийн бүс нутагчлах үйл явцад

илүү идэвхтэй оролцох замд түлхэн оруулсан ноцтой шалтгаан нь Азийн санхүүгийн хямрал болсон юм. Бээжин уг хямрал Хятадын эдийн засагт тархаж, Азийн санхүүгийн хямрал давтагдах аюул учирч мэднэ гэж үзсэн. Тиймээс ч ийм үзэгдлээс сэргийлэхийн тулд олон улсын хамтын ажиллагаанд оролцоход бэлэн байгаагаа яаравчлан зарласан юм. Нөгөөтэйгүүр Хятад улс одоо эдийн засгийн даяаршилд татагдаж байгаа арай бага хөгжилтэй олон орны нэг адилаар даяаршлыг юуны өмнө хөгжингүй орнуудаас хөгжлийн нэмэлт түлхэц, олж авах боломж хөгжингүй орнуудын санхүүгийн хийгээд оюуны нөөц бололцоог хөгжиж буй орнуудад ашигтайгаар “шударга” хуваарилах боломж гэж үзэж байна. Тэгэхдээ тусгаар тогтнолыг “хуваалцах шаардлагын тухай буюу даяаршлын нөгөө талын тухай асуудал зохистой шийдвэргүй хэвээр үлдэж байна. Хятад улс үндэснийхээ бүрэн эрхийн хагасыг олон улсын эдийн засгийн байгууллагуудад төлөөлүүлэхэд бэлэн болгох хүрээ хязгаарыг одоохондоо тогтоогоогүй байна. Энд бүс нутгийн хийгээд дэлхий нийтийн хэмжээнд аж ахуйн амьдралыг интеграцчлах үйл явц бодитой шаардлаг. Чухамдаа үүнд л даяаршлын гол шаардлагын утга учир утга оршиж байгаа бололтой. Энэ шаардлагад Хятад хариу өгөх ёстой. 1998 онд Куала-Лумпурт болсон Ази, Номхон далайн эдийн засгийн зөвлөлийн /АНДЭЗЗ/ дээд хэмжээний уулзалт дээр Азийн бүс нутагчлалын Хятадын үзэл баримтлалын үндэс гэж үзэж болох 3 саналыг Ази, Номхон далайн хамтын нийгэмд хандаж анх удаагаа тавьсан юм. Энэ нь:

- Азийн санхүүгийн хямрал тархахаас сэргийлж, хямралд нэрвэгдсэн эдийн засгийг сэргээх зорилгоор зайлшгүй шаардлагатай дэд бүтцийг бий болгохын тулд бүс нутгийн хоршилтыг хүчтэй болгох

- Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын эрх ашгийг хослуулж, санхүүгийн зах зээл дээр явуулах ажиллагааны аюулгүй байдлыг хангахуйц, дэлхийн санхүүгийн шинэ системийг олон улсын яриа хэлцээ, зөвлөмжөөр дамжуулан бий болгох

- Улс орон, бүс нутгууд хямралыг арилгах өөрсдийнхөө замыг бие даан сонгох явдлыг хүндэтгэх

- Бээжин дараачийн алхам болгож АСЕАН+3 /Хятад, Япон, БНСУ/ гэсэн хэлэлцээний хүрээнд санхүүгийн хамтын ажиллагааны асуудлаар яриа хэлцээг санаачлагч болсон юм. 2001 оны сүүлчээр тус улс Хятад, АСЕАН-ы хооронд чөлөөт худалдааны бүс байгуулах тухай бас нэг санаачилга дэвшүүлсэн. Үүний зэрэгцээгээр Хятад улс, БНСУ, Японы хооронд чөлөөт худалдааны бүс байгуулахыг сонирхож байна. Учир нь тэрээр Азийн хамгийн том эдийн засагтай нэгдэх боломжтой гэж үзэж буй ажээ.

Бээжин Ази Номхон далайн эдийн засаг, санхүүгийн хоршилтын үзэл санааг хөгжүүлж бусад хөгжиж буй орнуудыг даган, дэлхийн санхүүгийн тогтвортой байдлын төлөө хүлээх хөгжингүй орнуудын хариуцлагад “хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хоорондын зааг ялгааг багасгах, тэдгээрийн хөгжил цэцэглэлтийг эдийн засгийн хамтын ажиллагаагаар дамжуулан хангах” зайлшгүй шаардлагад анхаарлаа хандуулж байна.

Хятадын судлаачид даяаршил “бодит зүйл” гэдгийг хүлээн зөвшөөрч, “даяаршлаас айж эмээх бус, харин түүнд дасан зохицохыг” уриалан чухамдаа хөгжиж буй орнууд “даяаршлаас илүү их давуу байдал олж авна” гэдгийг цохон тэмдэглэж байна. Хятад улс бүсчлэл, даяаршлын тухай төсөөллөө өөрийнхөө түнш-хөгжингүй орнуудад нотлогдож батлагдсан төсөөлөлтэй холбон авч үзэх амаргүй замыг туулах хэрэгтэй болж байгаа бололтой. Гэхдээ ДХБ-д Хятад элсэн орсон нь цаг хугацааны хувьд Бээжин гадаад эдийн засгийн стратегээ үндсээр нь хянан үзсэнтэй давхцсан юм. Хятад улс одоо зөвхөн гадаадын хөрөнгийг /жилд барагцаалбал 40-50 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт/ өөртөө татаж, далайн чанадын зах зээлийг эзэмшихэд бэлэн төдийгүй бүс нутгийн хийгээд дэлхий нийтийн интеграцчиллын үйл явцад оролцох явдлаа шинэтгэлийг хэрэгжүүлэх нэн чухал хүчин зүйлийн нэг хэмээн үзэж түүнд бүх талаар анхаарал тавьж байна.

Хятадын эдийн засгийн даяаршлын өнөөгийн байдалд олон улсын байгууллага ямар үнэлэлт өгснийг энэхүү өгүүллийн дүгнэлт болгон толилуулъя. Парист төвтэй олон улсын Country rating үнэлгээний байгууллагаас 2005 онд Хятад улсын хувьд дараах үнэлгээг өгсөн байна. Үүнд:

Давуу талууд

Хятад Улс ДХБ-д элссэнээс хойш эрх барих байгууллага нь бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх үүргийг хариуцан ажиллаж байна.

Эдийн засгийн бүтэц нь тохиромжтой бөгөөд валютын нөөцтэй нь харьцуулахад гадаад өрийн хэмжээ нь харьцангуй бага.

Экспортын хэмжээ байнга өсч байдгаас гадаад худалдаан дээр байнга авлагатай байдаг.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ их тул Хятадын валютын нөөц байнга нэмэгдэж байдаг ба валютын нөөцөөрөө дэлхийд Японы дараа хоёрдугаарт ордог.

Банкны хадгаламжийн хэмжээ маш их.

Дадлага чадвартай, хямд ажиллах хүчин ихтэй.

Сул талууд

Аж үйлдвэрийн үндсэн салбарын хэт өндөр хүчин чадал нь нөгөө талаас хувийн хэвшлийн шинэчлэлд хүндрэл учруулдаг.

Улсын секторт олгосон муу зээлийн хэмжээ нь банкны салбарын үйл ажиллагаанд муугаар нөлөөлдөг.

Нийгэм, байгаль орчны асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ төрийн мэдлийн банк, аж үйлдвэрийн салбарын өөрчлөлтийг хэрэгжүүлэх, тэдгээрийн зах зээлийг тэлэхэд санхүүгийн ихээхэн нөөц шаардлагатай.

Хөгжлийн тэгш бус байдал нь эрэг хавийн баян муж, ядуу мужийн хооронд мөргөлдөөнт байдлыг дэвэргэдэг.

Хол зөрүүтэй нийгмийн тэгш бус байдал, ажилгүйчүүдийн тоо өсөж байгаа зэрэг нь Хятадын нийгмийн онцлог хэвээр аж.

Тайваньтай харилцах Хятадын харилцаа хурцадмал хэвээр байна

Эрсдэлийн үнэлгээний зэрэглэл А3

Улс төр, эдийн засгийн тааламжгүй нөхцөл байдлаас одоо ч төлбөрийн гүйцэтгэл үл биелэгдэх магадлалтай, өмнөх үзүүллэлтээс бага байгаа төлбөрийн тогтолцоонд энэ нь муугаар нөлөөлөх талтай байна.

Улс төрийн нөхцөл байдал тогтвортойд тооцогддог. 2002 оны сүүлч 2003 оны эхээр явагдсан коммунист нам, засгийн газрын удирдлага дахь тайван шинэчлэлтийн дараах одоогийн удирдагчид Ху Жинтао, Вэнь Зябао нар нэлээд прагматик бодлогыг баримталдаг. Бүс нутаг, нийгмийн тэгш бус байдлыг бууруулах, тогтвортой өсөлтийг хангасан эдийн засгийн шинэтгэлийн дэвшлийн төлөө өнөөгийн хятадын удирдлага идэвхтэй ажиллаж байна гэсэн үнэлгээ өгчээ.

Олон улсын үнэлгээний байгууллагын үнэлгээнээс харахад Хятадын нийгэм эдийн засгийн өсөлт хөгжилд сөрөг хүчин зүйлсээс эерэг хүчин зүйлс нь давамгайлж байна гэж үзэж болохоор байна.

Төгсгөлийн оронд

Хөрш гүрний эдийн засгийн өсөлт хөгжил манай улсын эдийн засаг, нийгмийн амьдралд шууд нөлөөлдөг тул Хятадын эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлт, аж үйлдвэрийн түүхий эдийн эрэлт хэрэгцээ, юаны ханшны өөрчлөлт, Хятадын эдийн засгийн гадаад бодлогын хувьсал, чиг хандлага зэрэг өргөн цар хүрээтэй асуудлуудыг тал бүрээс нь ултай судлан шинжлэх асуудал Монгол улсын хөгжлийн гадаад хүчин зүйлсийг тодорхойлоход шийдвэрлэх ач холбогдолтой. Манай банкирууд Хятадын юаний ханшны өөрчлөлт Монголын эдийн засагт

хэрхэн нөлөөлөх талаар ултай судалгаа хийсэн нь нэн олзуурхууштай. Ийм судалгааг тогтмол хийж, түүнийг төр засаг анхаарч бодлого, үйл ажиллагаандаа авч хэрэглэх шаардлагатй тийм байдал бий боллоо. Эдийн засгийн даяаршил, регионализмыг бид хүлээн зөвшөөрч байгаа юм бол ийм судалгаагүйгээр цааш явахгүй болжээ.

Ашигласан эх сурвалж:

1. Глобализация экономики Китая, Москва, “Памятники исторической мысли”, 2003
2. Китай 2003, Издательство “Синьсин”
3. Монгол Улсын статистикийн эмхэтгэл
4. А.И.Уткин. Глобализация: процесс и осмысления, Москва, “Логос” 2001
5. Asian Development Bank (Annual report) 2004
6. “Business Times “ 2005 оны дугаарууд
7. “Хөгжлийн эдийн засгийн асуудлууд” сэтгүүл 2004-2005 оны дугаарууд
8. The World in 2004
9. “The Economist” Journal 2003
10. “Өдрийн сонин” 2005.12.26